



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/178/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК
Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ	4-5
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ...	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв:	16
3.5.4.Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5.1 Албан шаардлага	19
5.2 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ, худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДСЦТС	Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ХУШААТ СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ О.БЯМБАЦЭЦЭГ ТАНАА**

2025.02.25. № СЭА-2025/114-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 10,901.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 9 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98,041,759.66	134,483,946.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	67,977,387.81	88,801,263.21
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	67,977,387.81	88,801,263.21
31210	Төгрөг	67,977,387.81	88,801,263.21
31211	Төрийн сангийн харилцах	67,977,387.81	88,801,263.21
33	АВЛАГА	146,166.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,918,205.85	45,682,683.00
351	Түүхий эд материал	2,110,300.00	27,810,300.00
3511	Тусгай зориулалттай материал	2,110,300.00	27,810,300.00
35400	Хангамжийн материал	27,807,905.85	17,872,383.00
35410	Бичиг хэргийн материал	616,060.00	0.00
35420	Аж ахуйн материал	12,153,543.00	11,231,683.00
35460	Хүнсний материал	10,617,602.85	0.00
35470	Бусад хангамжийн материал	4,420,700.00	6,640,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	490,961,443.43	490,575,699.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	490,961,443.43	490,575,699.32
39200	Биет хөрөнгө	482,197,255.93	481,811,511.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	175,026,127.00	475,026,127.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,932,025.91)	(51,045,233.47)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	34,474,835.00	55,066,835.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,183,858.89)	(18,475,292.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,739,293.90	24,807,693.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,927,115.17)	(3,568,618.21)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	300,000,000.00	0.00
39300	Биет бус хөрөнгө	8,764,187.50	8,764,187.50
39301	Програм хангамж	225,000.00	225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(182,812.50)	(182,812.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,722,000.00	8,722,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	589,003,203.09	625,059,645.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,550,891.26	2,121,150.78
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,550,891.26	2,121,150.78
413	Өглөг	1,550,891.26	2,121,150.78
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	2,121,150.78
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,550,891.26	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	587,452,311.83	622,938,494.75
51	Засгийн газрын хувь оролцоо	587,452,311.83	622,938,494.75
51100	Засгийн газрын оруулсан капитал	375,685,548.00	375,685,548.00
51200	Хуримтлагдсан үр дүн	111,313,553.50	146,799,736.42
51210	Өмнөх үеийн үр дүн	111,313,553.50	111,313,553.50
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	35,486,182.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,453,210.33	100,453,210.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	589,003,203.09	625,059,645.53

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	500,985,445.99	989,352,204.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,365,455.00	360,124,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,365,455.00	360,124,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,365,455.00	360,124,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,579,700.00	334,424,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,785,755.00	25,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,619,990.99	629,227,804.31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	441,687,500.00	54,499,104.31
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	441,687,500.00	54,499,104.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,932,490.99	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,932,490.99	0.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	574,728,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	574,728,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	427,795,377.97	653,866,021.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,795,377.97	653,866,021.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,795,377.97	646,780,021.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,007,507.09	443,830,168.70
210101	Үндсэн цалин	204,776,792.27	293,799,654.28
210102	Нэмэгдэл	76,089,030.92	131,279,189.42
210104	Урамшуулал	9,141,683.90	19,751,325.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,453,304.74	55,109,622.68
210201	Тэтгэврийн даатгал	29,118,610.91	38,339,608.86
210202	Тэтгэмжийн даатгал	3,425,523.09	4,412,916.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,740,652.66	2,206,456.40
210204	Ажилгүйдлийн даатгал	635,638.75	2,149,096.65
210205	Эрүүл мэндийн даатгал	6,532,879.31	8,001,542.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,483,382.25	39,478,213.05
210301	Гэрэл, цахилгаан	5,725,990.99	4,723,904.31
210302	Түлш, халаалт	33,557,391.26	33,554,308.74
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	1,537,920.00
210401	Бичиг хэрэг	0.00	616,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	921,860.00
2105	Нормативт зардал	29,347,253.58	39,896,152.85
210502	Хоол, хүнс	29,347,253.58	39,896,152.85
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	13,470,000.00

210604	Урсгал засвар	8,000,000.00	13,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	699,200.00	1,935,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	699,200.00	1,935,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,804,730.31	51,522,044.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,384,200.00	12,035,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,417,500.00	4,676,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,003,030.31	34,810,144.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	7,086,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	7,086,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	7,086,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	73,190,068.02	335,486,182.92
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	300,000,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	300,000,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-300,000,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	73,190,068.02	35,486,182.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	488,619,990.99	629,227,804.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,619,990.99	629,227,804.31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	441,687,500.00	54,499,104.31
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	441,687,500.00	54,499,104.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,932,490.99	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,932,490.99	0.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	574,728,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	574,728,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	429,537,868.82	608,403,928.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,537,868.82	608,403,928.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	429,537,868.82	601,317,928.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,153,673.09	438,898,874.60
210101	Үндсэн цалин	204,922,958.27	283,564,266.80
210102	Нэмэгдэл	76,089,030.92	135,626,982.80

210104	Урамшуулал	9,141,683.90	19,707,625.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,453,304.74	57,773,600.00
210201	Тэтгэврийн даатгал	29,118,610.91	39,286,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,425,523.09	4,621,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,740,652.68	2,311,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	635,638.75	2,311,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,532,879.31	9,243,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,932,490.99	41,029,104.31
210301	Гэрэл, цахилгаан	5,725,990.99	4,723,904.31
210302	Түлш, халаалт	32,006,500.00	35,105,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00
2105	Нормативт зардал	36,076,600.00	29,278,550.00
210502	Хоол, хүнс	36,076,600.00	29,278,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	13,470,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	13,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	699,200.00	1,775,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	699,200.00	1,775,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,222,600.00	19,091,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,124,900.00	14,085,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,097,700.00	5,006,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	7,086,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	7,086,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	7,086,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	59,082,122.17	20,823,875.40
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	59,082,122.17	20,823,875.40
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		67,977,387.81
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		88,801,263.21

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	111,313,553.50	587,452,311.83
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	35,486,182.92	35,486,182.92
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	146,799,736.42	622,938,494.75

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	694,680,404.31	608,403,928.91	86,276,475.40	87.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	694,680,404.31	608,403,928.91	86,276,475.40	87.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	687,594,404.31	601,317,928.91	86,276,475.40	87.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	512,375,200.00	438,898,874.60	73,476,325.40	85.7
210101	Үндсэн цалин	344,302,500.00	283,564,266.80	60,738,233.20	82.4
210102	Нэмэгдэл	157,954,200.00	135,626,982.80	22,327,217.20	85.9
210104	Урамшуулал	10,118,500.00	19,707,625.00	(9,589,125.00)	194.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,790,700.00	57,773,600.00	2,017,100.00	96.6
210201	Тэтгэврийн даатгал	40,658,800.00	39,286,000.00	1,372,800.00	96.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,782,200.00	4,621,900.00	160,300.00	96.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,391,600.00	2,311,000.00	80,600.00	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	2,391,600.00	2,311,000.00	80,600.00	96.6
210205	Эрүүл мэндийн даатгал	9,566,500.00	9,243,700.00	322,800.00	96.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,029,104.31	41,029,104.31	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,723,904.31	4,723,904.31	0.00	100.0
210302	Түлш, халаалт	35,105,200.00	35,105,200.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	37,729,600.00	29,278,550.00	8,451,050.00	77.6
210502	Хоол, хүнс	37,729,600.00	29,278,550.00	8,451,050.00	77.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,470,000.00	13,470,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	13,470,000.00	13,470,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,775,900.00	1,775,900.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,775,900.00	1,775,900.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,423,900.00	19,091,900.00	2,332,000.00	89.1

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,417,800.00	14,085,800.00	2,332,000.00	85.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,006,100.00	5,006,100.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,086,000.00	7,086,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,086,000.00	7,086,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,086,000.00	7,086,000.00	0.00	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	697,205,192.12	629,227,804.31	67,977,387.81	90.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,499,104.31	54,499,104.31	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	54,499,104.31	54,499,104.31	0.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС	574,728,700.00	574,728,700.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,977,387.81	67,977,387.81	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		88,801,263.21	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхдийн болон багшийн бүх талын тасралтгүй хөгжлийг хангахад хамтран ажиллах” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагчдыг цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлж “Чадварлаг багш”, “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх
- Сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлд суурилан тасралтгүй хөгжих олон хэлбэрт сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, менежментийг сайжруулах
- Багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх, үр ашигтай зарцуулахад идэвхтэй оролцох
- Багш бүр ээлжит хичээлийн цахим контентын санг бүрдүүлэхэд оролцох, бүтээлчээр ашиглах
- Мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлж, зөвлөх, тэргүүлэх багшийн манлайлал, үүрэг оролцоог нэмэгдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,056.5 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	67,977.40	88,801.30	20,823.90
Авлага	146.20		(146.20)
Бараа материал	29,918.20	45,682.70	15,764.50
Үндсэн хөрөнгө	490,961.40	490,575.70	(385.70)
Нийт хөрөнгө	589,003.20	625,059.70	36,056.50
Өр төлбөр	1,550.90	2,121.20	570.30
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	587,452.30	622,938.50	35,486.20
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	589,003.20	625,059.70	36,056.50

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 88,801.3 мянган төгрөг болж 20,823.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Авлага дансны үлдэгдэл 146.2 мянган төгрөгөөр буурсан нь цалин, НДШ-ийн авлагын барагдуулснаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 45,682.4 мянган төгрөг болж 15,764.5 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНСХ-ийн хөрөнгө оруулалтаар 8,500.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэл, БЕГ-с 17,200.0 мянган төгрөгийн тоглоом үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 59,690.4 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 60,625.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 563,847.7 мянган төгрөг болж 31,660.5 мянган төгрөгөөр өссөн нь МХШТ-ийн холбооноос 15,592.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, ДСЦТС ХХК-иас 5,000.0 мянган төгрөгийн 2-р хоолны тогоо, 4,500.0 мянган төгрөгийн хүүхдийн ор, сумын ОНСХ-ийн хөрөнгө оруулалтаар 9,332.4 мянган төгрөгийн гадна талбайн тоглоомыг үнэ төлбөргүй хүлээн авсан, аймгийн орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 389 дугаар албан бичгийн дагуу дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 300,000.0 мянган төгрөгийн өртөгтэй цэцэрлэгийн барилгыг үндсэн хөрөнгөд бүртгэн авсан, сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 10 дугаар тогтоолын дагуу 2,764.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг акталж данснаас хассан, 34,810.1 мянган төгрөгийн элэгдэлийн зардал байгуулснаас,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 2,121.2 мянган төгрөг болж 570.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд шинээр 2,121.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүссэнээс шалтгаалсан байна

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч

нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 499,001.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 56,616.7 мянган төгрөг нийт 555,617.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 61,669.1 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 39,171.7 мянган төгрөгөөр нийт 100,840.8 мянган төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,614.8 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардлыг 726.8 мянган төгрөгөөр нийт 13,341.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг нийт 468,118.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 224,937.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,983.8 мянган төгрөгөөр, мэдээллийн технологийн зардлыг 1,049.1 мянган төгрөгөөр нийт 228,970.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 290.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 2,117.6 мянган төгрөгөөр нийт 2,408.1 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 572,203.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 54,499.1 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 67,977.4 мянган төгрөг буюу нийт **694,680.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 694,680.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 608,403.9 мянган төгрөгийг зарцуулж, 86,276.5 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 608,403.9 мянган төгрөг буюу 87.6 хувьтай байгаа нь хоолны зардлыг 8,451.1 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 77,825.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
		1	80233-хүүхэд хамгаалал	811.3	811.3	-	100.0
1	71802-Сургуулийн өмнөх боловсрол	2	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,090.1	1,090.1	-	100.0
		3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	37,729.6	29,278.6	8,451.1	77.6
		4	81816- Зөв монгол хүүхэд	1,920.2	1,920.2	-	100.0
		5	81823- Боловсролын багшийн сургалт	1,090.1	350.0	740.1	32.1
		6	81834- Боловсролын стандарт сургалт	576,950.1	499,864.8	77,085.3	86.6

	7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	20,589.9	20,589.9	-	100.0
	8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	54,499.1	54,499.1	-	100.0
	Нийт		694,680.4	608,403.9	86,276.5	87.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4.Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	35,219.0	35,218.5	Харьцуулалт
	Нийт дүн	35,219.0	35,218.5	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад “Сэлэнгэ Шижир тулга” ХХК гүйцэтгэгчээр шалгаран 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундаръяа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 427,795.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,278.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 254.4 мянган төгрөгийн цалин илүү олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,697.1 мянган төгрөгийн авлага, өглөг үүсгэсэн, 10,617.6 мянган төгрөгийн хүүхдийн хоолны материал нөөцөлсөн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн авлага, өглөг үүсгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн гэж мэдээлсэн боловч өглөг үүсгэсэн зөрчил давтагдсан гарсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт тогтоох	1	254.4	1	254.4	100.0
Албан шаардлага	2	12,314.7	1	10,617.6	86.2
Нийт дүн	3	12,569.1	2	10,872.0	86.5

Өмнөх аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага, өглөг үүсгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй,бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч Д.Бат-Эрдэнэд **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт **22,047.1** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Хандив тусламжаар нийлүүлэгдсэн 19,420.0 мянган төгрөгийн тоглоомыг орлогод бүртгэж аваагүй,
- Санхүүгийн тайланд 4.0 мянган төгрөгийн авлага, 1,498.9 мянган төгрөгийн өглөг илүү тусгасан,
- Хангамжийн материалын зардлыг 1,124.2 мянган төгрөгөөр илүү тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **36,615.3** мянган төгрөгийн зөрчил илэрч, 570.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 36,045.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүллээ.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ын 570.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Д.Бат-Эрдэнэд **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 36,045.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 –ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хандиваар нийлүүлэгдсэн тоглоом орлогод бүртгэж аваагүй	1	19,420.0	1	19,420.0			1	19,420.0				
Авлага, өглөг илүү тусгасан	2	1,502.9			2	1,502.9	2	1,502.9				
Зардал илүү тусгасан	1	1,124.2			1	1,124.2	1	1,124.2				
Дүн	4	22,047.1	1	19,420.0	3	2,627.1	4	22,047.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өр төлбөр үүсгэсэн зөрчлийг давтан гаргасан	1	570.3									1	570.3		

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	36,045.0				1	36,045.0				
Дүн	2	36,615.3				1	36,045.0	1	570.3		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.